



180

МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/84

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны хуралдааны 15 дугаар тэмдэглэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/84 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Согтууруулах ундаа үйлдвэрлэгч Мандалговь Хүнс ХХК-ны үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд:

Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Э.Бямбасүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч)

Н.Болормаа (Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)

М.Эрдэнэбаатар (Стандарт хэмжил зүйн хэлтсийн даралтын хэмжлийн улсын шалгагч)

Б.Доржхорол (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, дэслэгч)

Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын Дэд дарга, дэд хурандаа)

438190625

Ч.Оюунжаргал (Татварын хэлтсийн татварын улсын
байцаагч)

Нарийн бичгийн дарга: Б.Цэрэнханд (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Хоёр. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгч Мандалговь хүнс ХХК-ны
үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гарсан дүгнэлт
саналыг 2019 оны 6 сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн
ахлагч (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ